

## ТОХИРОХ АЖИЛД НЬ ЗӨВ ХҮНИЙГ *career nudge*

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Хөдөлмөрийн зах зээлд шинээр хөл тавих МУИС-ыг төгсөх ангийн оюутан залуусын зан төлөв, авьяас сонирхол хандлага, ур чадварыг технологийн дэвшил ашиглан дэлгэрэнгүй тодорхойлж, карьер хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлж, ажил амьдралын сорилтуудыг амжилттай даван туулах төлөвлөгөөтэй, өрсөлдөх чадвартай, баялаг бүтээгчийг тохирох ажлын байранд санал болгоход энэхүү төслийн зорилго оршино.



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН 70 % ОРЧИМ ХУВЬ ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА


Шинэхэн төгсөгч ажил горилогчийн зүгээс өөрийн давуу тал, ур чадвараа үнэлж карьер төлөвлөлтөө хийж чадахгүй байгаагаас өөрийн тохирох, төлөвлөсөн ажлын байранд өргөдөл гаргаж хүчээ сорьж чадахгүй байна.

ТОХИРОХ АЖИЛД НЬ ЗӨВ ХҮНИЙГ СОНГОН БАЙРШУУЛЖ БҮТЭЭМЖЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ БАЙГУУЛЛАГЫН ХАМГИЙН ЧУХАЛ СОРИЛТ БОЛООД БАЙНА.

Ажил олгогч, байгууллагын зүгээс ажилтанд тавих хандлага, ур чадварыг тоочин жагсааж байгаа боловч шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлж ажилтан сонгон шалгаруулах болон ажилтанаа хөгжүүлэх үйл явцдаа ашиглаж чадахгүй байсаар байна

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. ӨӨРИЙГӨӨ НЭЭ КАРЬЕРАА УДИРД – ЛЕКЦ
2. КАРЬЕР ИНКУБАТОР
3. ICAREER ОНЛАЙН ҮЗЭСГЭЛЭН
4. АЖЛЫН БАЙР & КАРЬЕРЫН ҮЗЭСГЭЛЭН



### 1.ӨӨРИЙГӨӨ НЭЭ КАРЬЕРАА УДИРД – ЛЕКЦ

**ЮУ:** Хэрхэн өөрийгөө таньж мэдэх , карьераа төлөвлөх , амжилтанд чиглүүлэх талаарх өргөн хүрээтэй , системтэй , шинэлэг мэдээлэл олгож сэдэлжүүлэх лекцыг төгсөх ангийн оюутануудад зохион байгуулна.

**СЭДЭВ:** Миний карьер төлөвлөлт , Үнэ цэнэтэй ажилтаны амжилтын томьёо, Амжилтанд хөтлөх ур чадварууд, Энтрепренерын амжилтын 10 дүрэм

**ХЭН:** Карьер хөгжлийн төвийн захирал, карьер зөвлөх Д.Мөнхнаран, Дейл Карнеги сургалтын төвийн захирал Э.Чинзориг, NCS зөвлөх компаны захирал Д.Болор, Юнайтед Бизнес Ревью захирал Д.Асралт

**ХЭНД:** МУИС-ийн төгсөх ангийн оюутнуудад

**ҮР ДҮН:** Хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй ажилтаны хандлага ,ур чадвар  
Хөдөлмөрий зах зээлд өөрийгөө амжилттай борлуулах боломжуудын талаарх мэдээллээр хангагдана.

**ТӨСӨВ:**

## 2. КАРЬЕР ИНКУБАТОР

**ЮУ:** Карьер инкубацын үйлчилгээг үзүүлнэ.

Энэхүү төслийн хүрээнд бид “Карьер инкубатор” үйлчилгээг анх удаа үзүүлэх гэж байна. “Карьер инкубатор” үйлчилгээний гол зорилго нь шинэхэн төгсөгч оюутан залуусыг дэмжин, хувь хүн талаасаа өөрийгөө таньж мэдэх, давуу болон сул талаа тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлд гарах эхний шаардлагуудад нийцэх, хүссэн ажилдаа тохирох хүн нь болоход нь туслах юм.

“Карьер инкубатор” үйлчилгээ нь Олон улс (ОУ)-ын 80 гаруй оронд хэрэглэгддэг, ОУ-ын сорилын хороо (ИТС)-оор баталгаажсан, Америкийн сэтгэл судлалын хүрээлэн (АРА) болон Англи улсын сэтгэл судлалын хүрээлэн (ВРА)-ээр баталгаажсан Central test-ийн сорилын арга, болон карьер хөгжлийн цогц сургалт, зөвлөгөө хэлбэрээр явагдана.



КАРЬЕР  
ҮНЭЛГЭЭ

КАРЬЕР  
ХӨГЖЛИЙН  
ЦОГЦ  
СУРГАЛТ

КАРЬЕР  
ТӨЛӨВЛӨЛТ

КАРЬЕР  
ЗУУЧЛАЛ

## 2.1 КАРЬЕР ҮНЭЛГЭЭ

**BIG 5** - ХУВЬ ХҮНИЙ ЗАН ЧАНАРЫН ОНЦЛОГ 5 ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ

**PROFESSIONAL PROFILE** - АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГ, ЧАДВАР ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ

**СТРИ-** МЕНЕЖЕРЫН УР ЧАДВАРЫН ТОДОРХОЙЛОХ ТЕСТ

**SALES PROFILE** - БОРЛУУЛАЛТЫН УР ЧАДВАРЫГ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ

**TALENT MAP** - АВЪЯАСЫН ОЛОН ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЗУРАГЛАЛД ҮНДЭСЛЭН ДҮГНЭЛТ ГАРГАХ

Оролцогчдод карьерын иж бүрэн үнэлгээ хийж авьяасын олон талын хүчин зүйлийн зураглалыг нь тодорхойлж өгнө.

## 2.2 КАРЬЕР ХӨГЖЛИЙН ЦОГЦ СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

Өөрийн бусдаас ялгарах онцлог зан чанар, хандлага, ур чадвар давуу сул талаа бүрэн тодорхойлсон шинэхэн төгсөгчдөд карьер хөгжлийн цогц сургалтаар хөдөлмөрийн зах зээлд өөрийгөө амжилттай борлуулах чадварыг эзэмшүүлнэ.

**ЗАГВАРЛАГ CV** тоогдохоор, ойлгомжтой, тодорхой бичих г.м

**СОЛОНГОРСОН RESUME** хувийн онцлог зан чанар, хандлага, ур чадвар, туршлагаа амжилттай сийрүүлэх нь

**АМБИЦТАЙ COVER LETTER** ажилд орох хүсэлтээ карьер төлөвлөлттэйгээ уялдуулан илэрхийлэх нь

**МИНИЙ КАРЬЕР ТӨЛӨВЛӨЛТ**

**ИНВАТОР& ЭНТРЕПРЕНЕР**

## 2.3 КАРЬЕР ЗУУЧЛАЛ

Байгууллагын нээлттэй ажлын байрны шаардлагад тохирох төгсөгчийг зуучилна

**ХЭН:** Карьер хөгжлийн төв

**ХЭНД:** МУИС-ийн төгсөх ангийн хүсэлтээ илгээсэн эхний 100 оюутан

**ҮР ДҮН:** Өөрийгөө таньж мэдсэн, хувийн карьер төлөвлөлттэй шинэхэн төгсөгч Шаардлагатай ажлын байранд тохирох ажилтан

### **3. I CAREER ОНЛАЙН ҮЗЭСГЭЛЭН**

**ЮУ:** Карьерын онлайн үзэсгэлэн

Ажлын байран дахь хувь хүний хандлага, ур чадвараа тодорхойлж, карьер төлөвлөлтөө боловсруулсан шинэхэн төгсөгч оюутануудад өөрийн карьераа борлуулах, ажил олгогчдод ур чадварын шаардлагад нийцсэн ажилтан сонгох боломжыг олгох зорилгоор онлайн карьер үзэсгэлэнг анх удаа зохион байгуулахаар төлөвлөж байна.

**ХЭН:** Карьер хөгжлийн төв



**ХЭНД:** МУИС-ийн төгсөх ангийн оюутанууд , ААН байгууллага

**ҮР ДҮН:** Төгсөгчдийн хандлага, ур чадвар, мэдлэг туршлага, карьер төлөвлөлтийг салбар болон мэргэжлээр ангилан нэг дороос харах боломж

Карьер төлөвлөлтөө хийсэн оюутнууд өөрийн хүсэж буй, тохирох ажлын байранд шууд орох боломж

Ажлын байран дахь хандлага, ур чадвараа үнэлүүлсэн шинэхэн төгсөгчдөөс байгууллагын ур чадварын шаардлагад нийцсэн ажилтан сонгох боломжыг олгоно.

## 4. АЖЛЫН БАЙР & КАРЬЕРЫН ҮЗЭСГЭЛЭН



Нэг талаас байгууллагын нээлттэй ажлын байр, түүнд тавигдах шаардлагууд, байгууллагын соёлын талаархи танилцуулга нөгөө талаас хандлага, ур чадвараа тодорхойлсон, хувийн карьер төлөвлөлттэй төгсөгчид өөрийн амбицаа ажил олгогчид танилцуулах улмаар ажил хэрэгч уулзалт зохион байгуулж хамтран ажиллах боломжыг бий болгоно.



### **ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:**

2018-04-24 наас 2018-05-25 ны хооронд явагдана.

### **ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

Юнайтед Карьер Консалтинг ХХК, Карьер Хөгжлийн Төв  
Монгол Улсын Их Сургууль, Оюутны хөгжил үйлчилгээний газар

**КАРЬЕРЫН ЗӨВ ЭХЛЭЛ  
МӨРӨӨДЛИЙН АМЖИЛТЫН ЭХЛЭЛ**